



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

“ЖДҮХС-гаас урт хугацаатай,
хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон
шалгаруулах журам”-ын төслийн
танилцуулга

Улаанбаатар хот
2019.04.11



Журмын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

- **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ:** Журмын зорилго, хамрах хүрээ, зээлийн эх үүсвэр, нөхцөл, зээл олгох хэлбэр, хэмжээ, дамжуулан зээл олгох банкыг сонгохтой холбоотой асуудал
- **ХОЁРДУГААР БҮЛЭГ:** Хөнгөлөлттэй зээлд хамрагдах төсөлд тавигдах шаардлага
- **ГУРАВДУГААР БҮЛЭГ:** Төсөл сонгон шалгаруулах хороо, дэд хорооны бүрэлдэхүүн, эрх, үүрэг
- **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ:** Төсөл сонгон шалгаруулалт зарлах, хүлээн авах
- **ТАВДУГААР БҮЛЭГ:** Төсөл сонгон шалгаруулах үе шат, ил тод байдал
- **ЗУРГААДУГААР БҮЛЭГ:** Гэрээ байгуулах, санхүүжилт олгох
- **ДОЛООДУГААР БҮЛЭГ:** Бусад зүйл



Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журмын зорилго

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.2, 14.6 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтыг үндэслэн экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин, шинээр бизнес эхлүүлэх болон ажлын байр бий болгож, нэмэгдүүлэх



ЖДҮХС-ГААС ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОХ ЖУРАМД ОРЖ БУЙ ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮД

1. Хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр, төсөл сонгон шалгаруулах эрхийг орон нутагт шилжүүлсэн
2. Төсөл сонгон шалгаруулах хорооны бүрэлдэхүүнийг тодорхой болгож, төрийн бус байгууллагын төлөөллийг нэмэгдүүлсэн
3. Хөнгөлөлттэй зээлийг дамжуулан олгох арилжааны банкинд тавигдах шаардлагыг бий болгосон
4. Хөнгөлөлттэй зээл авах жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд тавигдах шаардлагыг иргэн, хуулийн этгээдээр салгаж, тодорхой болгосон
5. Төсөл хүлээн авах хугацааны товыг тогтоохдоо жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд төсөл бичих хугацаа олгох зохицуулалтыг хийсэн
6. ЖДҮЭ-ийн төслийг хүлээн авах, шалгах, судалгаа хийх, хурлаар хэлэлцүүлэх зэрэг үе шат бүрийг нарийвчлан зааж хариуцлагыг нэмэгдүүлсэн



ЖДҮХС-ГААС ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОХ ЖУРАМД ОРЖ БУЙ ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮД

7. Хөнгөлөлттэй зээл авсан жижиг, дунд үйлдвэр эрхлэгч, санхүүжүүлж буй байгууллага хооронд уялдааг сайжруулах, харилцан уялдаатай, хяналттай байдлаар ажиллах зохицуулалт оруулсан
8. ЖДҮХС, зээлдэгчийн эрсдэлийг бууруулах зорилгоор даатгалын асуудлыг оруулсан
9. Төсөл хүлээн авах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэн хялбаршуулахаар болсон
10. Эцсийн шатны төсөл сонгон шалгаруулалтыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд ил тод, нээлттэй харуулах
11. Онооны системээр дүгнэх
12. Тэргүүлэх чиглэлийг тодорхойлох
13. ЖДҮХС-гаас шууд олгох тохиолдолд даатгалд заавал хамрагдах



ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР ЭРХЛЭГЧ НЬ ЯМАР ТОХИОЛДОЛД ЗЭЭЛ АВЧ ЧАДАХГҮЙ ВЭ?


- Нийт санхүүжилтийн 30-аас доошгүй хувийг өөрийн эх үүсвэрээр бүрдүүлээгүй;
- Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.6, 5.4.8, 5.4.14-т заасан сангуудад болон сум хөгжүүлэх санд төлөх чанаргүй зээлийн үлдэгдэлтэй;
- Сангаас авсан зээлээ төлсөн боловч зориулалтын бусаар ашигласан;
- Монгол банкны зээлийн мэдээллийн санд чанаргүй зээлийн түүхтэй;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын өртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн;
- Нийгмийн даатгал болон татварын байгууллагад өртэй;
- Байгаль орчин ба хүний эрүүл мэндэд хортой технологи, материал хэрэглэсэн, экологийн хохирол учруулсан нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон;
- Тухайн төсөл болон төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг зөвшөөрөөгүй.

ТӨСӨЛ ХҮЛЭЭН АВАХ, СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ЯВУУЛАХ ҮЕ ШАТ

№	Төсөл сонгон шалгаруулах хороо	Төсөл авах газар	Бүрэлдэхүүн	Төслийн санхүүжилт	Шийдвэр	Баталгаажуулах
1	Хороо	ЖДҮХС	Төрийн байгууллага - 4 ТТБ-ын төлөөлөл – 3	Аймаг 200,0 -, Улаанбаатар 20,0-1000,0 сая хүртэл	Банкинд хүргүүлэх	Банкнаас хуанлийн 30 хоногийн хугацаанд хэрхэн шийдвэрлэсэн талаар санд ирүүлнэ. Сайдын тушаалаар баталгаажуулна.
2	Дэд хороо	Аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага /ХХААГ/	Төрийн байгууллага - 4 ТТБ-ын төлөөлөл - 3	Аймаг 200,0 сая хүртэл,	Банкинд хүргүүлэх	Банкнаас хуанлийн 30 хоногийн хугацаанд хэрхэн шийдвэрлэсэн талаар санд ирүүлнэ. Сайдын тушаалаар баталгаажуулна.



Төсөл хүлээн авах, сонгон шалгаруулалт явуулах үе шат.





ДАМЖУУЛАН ЗЭЭЛ ОЛГОХ БАНКИНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Монгол банкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, заавал байлгах нөөцийн шаардлагыг сүүлийн 1 жил хангасан байх бөгөөд энэ талаар Монгол банкны дүгнэлтийг хавсаргасан байна;
- Аймгийн төвд салбартай байх
- Зээлийн үйл ажиллагаатай холбоотой аливаа эрсдэлийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн өмнө хариуцах баталгаа гаргасан байх;
- Хөнгөлөлттэй зээлийн хүүгийн хэмжээ тухайн банкны өөрийн жижиг, дунд үйлдвэрийн зориулалттай зээлийн хүүгийн доод түвшингээс бага байх бөгөөд зээлийн хүүг банктай байгуулах гэрээнд тусган гэрээний туршид банкны олгож байгаа хүүгийн доод түвшингээс доогуур байх;
- Сүүлийн 3 жилийн хугацаанд сангаар дамжуулан олгосон зээлийн хугацаа хэтэрсэн зөрчилгүй байх;
- Сонгон шалгаруулалтын үеэр тавьсан бусад шаардлагыг хангасан байх.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 87-Р ТОГТООЛД ТУСГАСАН ЗААЛТУУДАЙ УЯЛДУУЛСАН БАЙДАЛ

/Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай/

Засгийн газрын 87-р тогтоолын заалт	ЖДҮХС-аас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журмын заалт
<p>6.1 Төсвийн хөрөнгөөс зээл, тусламж авсан, батлан даалт гаргуулсан, санхүүгийн дэмжлэг авсан хувь хүний овог нэр, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, шалгарсан төслийн нэр, үйл ажиллагааны чиглэл, төсөл хэрэгжиж байгаа байршил, сонгон шалгаруулсан шийдвэр, зээлийн төлөв, зээлийн үлдэгдлийг Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн дагуу байгууллагын шилэн данс, цахим хуудсаараа дамжуулан тогтмол мэдээлэх;</p>	<p>18 дугаар зүйл. Хороо, дэд хороо нь төсөл сонгон шалгаруулах, үнэлэх үйл явцыг цахимаар болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй, ил тод зохион байгуулна.</p> <p>20 дугаар зүйл. Хороо болон дэд хорооны хурлын шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан төсөл ирүүлсэн иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан мэдээлнэ. Төсөл ирүүлэгчийн хүсэлтийн дагуу албан бичгээр хариуг өгнө.</p> <p>21 дүгээр зүйл. Төсвийн хөрөнгөөс хөнгөлөлттэй зээл авсан хувь хүний овог нэр, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, шалгарсан төслийн нэр, үйл ажиллагааны чиглэл, төсөл хэрэгжих байршил, сонгон шалгаруулсан шийдвэрийг Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн дагуу байгууллагын шилэн данс, цахим хуудсаараа дамжуулан нийтэд ил тод мэдээлнэ.</p>



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 87-Р ТОГТООЛД ТУСГАСАН ЗААЛТУУДАЙ УЯЛДУУЛСАН БАЙДАЛ

/Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай/

Засгийн газрын 87-р тогтоолын заалт	ЖДҮХС-аас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журмын заалт
<p>6.2. Хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах шат дараалсан арга хэмжээ авч, гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгжүүдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах, улсын төсвийг хохиролгүй болгох, мөн ажлын хариуцлага алдсан төрийн албан хаагчид холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж байх;</p>	<p>25 дугаар зүйл. Арилжааны банкаар дамжуулан олгосон зээлийг зориулалт бусаар ашигласан, хууль, журам зөрчиж олгосон нь хяналт, шалгалтаар тогтоогдсон тохиолдолд зээл авсан өдрөөс эхлэн уг зээлийг дамжуулан олгосон банкны арилжааны зээл рүү шилжүүлэх арга хэмжээ авч, тухайн зээлийн эх үүсвэрийг арилжааны банкны эх үүсвэрээс бүрэн дүнгээр нь Санд буцаан төвлөрүүлнэ. Энэ зохицуулалтыг сан, арилжааны банктай хамтран ажиллах гэрээгээр нарийвчлан зохицуулна.</p> <p>26 дугаар зүйл. Сангаас шууд олгосон зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь сангийн хяналт, шалгалтаар тогтоогдсон бол зээлдэгчийн эх үүсвэрийг буцаан татаж, холбогдох байгууллагад шилжүүлнэ.</p>



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 87-Р ТОГТООЛД ТУСГАСАН ЗААЛТУУДАЙ УЯЛДУУЛСАН БАЙДАЛ

/Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай/

Засгийн газрын 87-р тогтоолын заалт	ЖДҮХС-аас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журмын заалт
<p>6.2. Хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах шат дараалсан арга хэмжээ авч, гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгжүүдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах, улсын төсвийг хохиролгүй болгох, мөн ажлын хариуцлага алдсан төрийн албан хаагчид холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж байх;</p>	<p>8.5 хороо, дэд хороо нь гаргасан шийдвэрээ болон хорооны гишүүд тавьсан оноогоо бүрэн хариуцна.</p> <p>9.5 Сан болон аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь өөрийн судалдсан төслийн үнэн зөвийг бүрэн хариуцна.</p>



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 87-Р ТОГТООЛД ТУСГАСАН ЗААЛТУУДАЙ УЯЛДУУЛСАН БАЙДАЛ

/Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай/

Засгийн газрын 87-р тогтоолын заалт	ЖДҮХС-аас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журмын заалт
<p>6.3. Шинээр олгох зээлийн эх үүсвэрийн хэмжээ, сонгон шалгаруулалтын журам, тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг цахим хуудсаараа дамжуулан мэдээлэх, мэдээллийг тогтмол шинэчлэх;</p>	<p>10.1. Төсөл хүлээн авах зарыг өдөр тутмын мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх үүргийг сан, аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн байгууллага хариуцна. Төсөл хүлээн авах зард төсөл хүлээн авч эхлэх, дуусах хугацаа, байршил, зээлийн нөхцөл, холбоо барих утасны дугаар зэрэг мэдээллийг тусгасан байна.</p>



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 87-Р ТОГТООЛД ТУСГАСАН ЗААЛТУУДАЙ УЯЛДУУЛСАН БАЙДАЛ

/Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай/

Засгийн газрын 87-р тогтоолын заалт	ЖДҮХС-аас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журмын заалт
<p>6.4. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй, зээлийн муу түүхтэй хуулийн этгээд, иргэдэд зээл олгохгүй байх зохицуулалтыг зээл, батлан даалт, санхүүгийн дэмжлэг олгох журам, дамжуулан зээлийн гэрээнд тусгаж мөрдүүлэх;</p>	<p>1.4.2. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.6, 5.4.8, 5.4.14-т заасан сангуудад болон сум хөгжүүлэх санд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй;</p> <p>/ЗГ-ын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.4.6. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан; 5.4.8. Мал хамгаалах сан; 5.4.14. Тариаланг дэмжих сан; /</p> <p>1.4.4. Монголбанкны зээлийн мэдээллийн санд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй, зээлийн муу түүхтэй ;</p>



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 87-Р ТОГТООЛД ТУСГАСАН ЗААЛТУУДАЙ УЯЛДУУЛСАН БАЙДАЛ

/Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай/

Засгийн газрын 87-р тогтоолын заалт	ЖДҮХС-аас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журмын заалт
<p>6.5. Зээл, батлан даалт, санхүүгийн дэмжлэгийн журам, дамжуулан зээл, дэд зээлийн гэрээний загваруудад зээл, батлан даалтыг банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан олгох эрсдэлийг тооцох зохицуулалтыг тусгаж мөрдүүлэх;</p>	<p>27 дугаар зүйл. Энэхүү төсөл сонгон шалгаруулахтай холбоотойгоор нарийвчлан зохицуулаагүй бусад харилцаа болон төслийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахтай холбогдсон харилцааг сангийн захирлын баталсан журмаар зохицуулна.</p>



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 87-Р ТОГТООЛД ТУСГАСАН ЗААЛТУУДАЙ УЯЛДУУЛСАН БАЙДАЛ

/Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай/

Засгийн газрын 87-р тогтоолын заалт	ЖДҮХС-аас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журмын заалт
<p>6.5. Зээл, батлан даалт, санхүүгийн дэмжлэгийн журам, дамжуулан зээл, дэд зээлийн гэрээний загваруудад зээл, батлан даалтыг банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан олгох эрсдэлийг тооцох зохицуулалтыг тусгаж мөрдүүлэх;</p>	<p>Дөрөвдүгээр бүлэг. 10 дугаар зүйл. Төсөл сонгон шалгаруулалт зарлах, хүлээн авах 10.1 Төсөл хүлээн авах зарыг өдөр тутмын мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх үүргийг сан, аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн байгууллага хариуцна. Төсөл хүлээн авах зард төсөл хүлээн авч эхлэх, дуусах хугацаа, байршил, зээлийн нөхцөл, холбоо барих утасны дугаар зэрэг мэдээллийг тусгасан байна. 10.2. Аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага нь тухайн орон нутагт хэрэгжих 200,0 сая хүртэл төгрөгийн санхүүжилт хүссэн төслийг цаасан хэлбэрээр хүлээн авна.</p>



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 87-Р ТОГТООЛД ТУСГАСАН ЗААЛТУУДАЙ УЯЛДУУЛСАН БАЙДАЛ

/Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай/

Засгийн газрын 87-р тогтоолын заалт	ЖДҮХС-аас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журмын заалт
<p>6.5. Зээл, батлан даалт, санхүүгийн дэмжлэгийн журам, дамжуулан зээл, дэд зээлийн гэрээний загваруудад зээл, батлан даалтыг банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан олгох эрсдэлийг тооцох зохицуулалтыг тусгаж мөрдүүлэх;</p>	<p>10.3. Сан нь орон нутагт хэрэгжүүлэх 200,000,000 /хоёр зуун сая/ төгрөгөөс 1,000,000,000 /нэг тэрбум/ хүртэл, Улаанбаатар хотод хэрэгжүүлэх 20,000,000 /хорин сая/ төгрөгөөс 1,000,000,000 /нэг тэрбум/ төгрөг хүртэл санхүүжилт хүссэн төслийг цахимаар эсхүл цаасан хэлбэрээр хүлээн авна.</p> <p>10.4. Сан, аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага нь төсөл хүлээн авах хугацаа зарлагдахаас бусад үед төсөл хүлээн авахгүй.</p> <p>Мэргэжилтэн хариуцахаар заасныг тухайн байгууллага хариуцахаар зааж төсөл хүлээн авагчийн мэдээллийг тодорхой болгосон.</p>



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 87-Р ТОГТООЛД ТУСГАСАН ЗААЛТУУДАЙ УЯЛДУУЛСАН БАЙДАЛ

/Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай/

Засгийн газрын 87-р тогтоолын заалт	ЖДҮХС-аас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журмын заалт
<p>6.6. Зээл, батлан даалт, санхүүгийн дэмжлэгийг Монголбанкнаас хийсэн активын чанарын үнэлгээний үр дүнгээр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлагыг бүрэн хангасан, банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол ханган ажиллаж байгаа, хөдөө орон нутагт салбартай банкуудаар дамжуулан олгох зохицуулалтыг холбогдох журамд тусгаж мөрдүүлэх;</p>	<p>4.3.1. Монгол банкнаас хийсэн активын чанарын үнэлгээний үр дүнгээр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлагыг бүрэн хангасан, банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол ханган ажиллаж байгаа нь Монгол банкны дүгнэлтээр нотлогдсон;</p> <p>4.3.2. Аймгийн төвд салбартай байх;</p>



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 87-Р ТОГТООЛД ТУСГАСАН ЗААЛТУУДАЙ УЯЛДУУЛСАН БАЙДАЛ

/Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай/

Засгийн газрын 87-р тогтоолын заалт	ЖДҮХС-аас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журмын заалт
<p>6.8. Олгосон зээл, санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, зориулалт бусаар ашигласан зээлийн эх үүсвэрийг дамжуулан олгож байгаа банк, санхүүгийн байгууллагаар үл маргах журмаар эргүүлэн төлүүлэх, тухайн банк, санхүүгийн байгууллагад дахин эх үүсвэр олгохгүй байх зохицуулалтыг холбогдох гэрээнд тусгах;</p>	<p>25 дугаар зүйл. Арилжааны банкаар дамжуулан олгосон зээлийг зориулалт бусаар ашигласан, хууль, журам зөрчиж олгосон нь хяналт, шалгалтаар тогтоогдсон тохиолдолд зээл авсан өдрөөс эхлэн уг зээлийг дамжуулан олгосон банкны арилжааны зээл рүү шилжүүлэх арга хэмжээ авч, тухайн зээлийн эх үүсвэрийг арилжааны банкны эх үүсвэрээс бүрэн дүнгээр нь Санд буцаан төвлөрүүлнэ. Энэ зохицуулалтыг сан, арилжааны банкт хамтран ажиллах гэрээгээр нарийвчлан зохицуулна.</p> <p>4.3.5. Сүүлийн 3 жилийн хугацаанд сангаар дамжуулан олгосон зээлийн хугацаа хэтэрсэн зөрчилгүй байх;</p>



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 87-Р ТОГТООЛД ТУСГАСАН ЗААЛТУУДАЙ УЯЛДУУЛСАН БАЙДАЛ

/Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай/

Засгийн газрын 87-р тогтоолын заалт	ЖДҮХС-аас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журмын заалт
<p>6.9. Төсөл сонгон шалгаруулах хороо, төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодыг оролцуулах замаар зээл олголт, зээлийн хяналт, мониторингийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх;</p>	<p>6.3. Хороо, дэд хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллагын 3 төлөөлөл байна.</p>



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 87-Р ТОГТООЛД ТУСГАСАН ЗААЛТУУДАЙ УЯЛДУУЛСАН БАЙДАЛ

/Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай/

Засгийн газрын 87-р тогтоолын заалт	ЖДҮХС-аас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журмын заалт
<p>6.10. Зээл авахаар хүсэлт ирүүлсэн иргэд, аж ахуйн нэгжийн бизнес төлөвлөгөөгөө танилцуулах, түүнийг сонгон шалгаруулах, үнэлэх үйл явцыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй, ил тод, зохион байгуулах зохицуулалтыг холбогдох журамд тусгаж мөрдүүлэх;</p>	<p>5.8.11. Тухайн төсөл болон төсөл хэрэгжүүлэгчийн талаархи мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг зөвшөөрөх эсэхийг илэрхийлсэн мэдэгдэл. /Иргэн/</p> <p>5.9.13. Тухайн төсөл болон төсөл хэрэгжүүлэгчийн талаархи мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг зөвшөөрөх эсэхийг илэрхийлсэн мэдэгдэл. /Аж ахуйн нэгж/</p> <p>18 дугаар зүйл. Хороо, дэд хороо нь төсөл сонгон шалгаруулах, үнэлэх үйл явцыг цахимаар болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй, ил тод зохион байгуулна.</p>



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 87-Р ТОГТООЛД ТУСГАСАН ЗААЛТУУДАЙ УЯЛДУУЛСАН БАЙДАЛ

/Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай/

Засгийн газрын 87-р тогтоолын заалт	ЖДҮХС-аас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журмын заалт
<p>6.11. Олгосон зээл, дэд зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн сан, Сангийн яамны өрийн удирдлагын мэдээллийн санд тогтмол бүртгүүлэх, зээл олгох шийдвэр гаргалтад зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;</p>	<p>Зээлдэгчийн мэдээллийг ЖДҮХС-гаас Монгол банкны зээлийн мэдээллийн санд нэгтгэх ажиллагаа хэвээр үргэлжилнэ.</p> <p>Сангийн яамтай байгуулж байгаа гэрээний хүрээнд 2019 оноос эхлэн ЖДҮХС-гийн зээлдэгчийн мэдээллийг Сангийн яамны өрийн удирдлагын мэдээллийн санд тогтмол бүртгүүлэхээр тохирсон.</p>



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 87-Р ТОГТООЛД ТУСГАСАН ЗААЛТУУДАЙ УЯЛДУУЛСАН БАЙДАЛ

/Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай/

Засгийн газрын 87-р тогтоолын заалт	ЖДҮХС-аас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журмын заалт
<p>6.12. Төсөлд зээл, санхүүжилт олгох, батлан даалт гаргах шийдвэрийг гаргах болон гаргахад оролцох эрх бүхий этгээд нь ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх;</p>	<p>8.1. хороо, дэд хорооны гишүүн нь ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж ашиг сонирхлын баталгааны хуудас бөглөх, хувийн ашиг сонирхолд нөлөөлөхүйц шийдвэр гаргах тохиолдолд хуралд оролцохоос татгалзаж, татгалзах хүсэлтээ бичгээр хороо болон дэд хорооны даргад гаргах;</p> <p>9.4. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, бусад хууль тогтоомж, энэ журам болон эдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллах.</p>



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 87-Р ТОГТООЛД ТУСГАСАН ЗААЛТУУДАЙ УЯЛДУУЛСАН БАЙДАЛ

/Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай/

Засгийн газрын 87-р тогтоолын заалт	ЖДҮХС-аас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журмын заалт
<p>6.13. Төсөл сонгон шалгаруулах, зээл олгох, эргэн төлүүлэх үйл ажиллагааг цахимжуулах, мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлэх замаар төрөөс иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгох хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэгийг түргэн шуурхай, ил тод, хүртээмжтэй болгох арга хэмжээ авах;</p>	<p>19 дүгээр зүйл. Сан, аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага нь төслийн судалгааны явцыг тухай бүр цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдээлнэ.</p> <p>20 дугаар зүйл. Хороо болон дэд хорооны хурлын шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан төсөл ирүүлсэн иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан мэдээлнэ. Төсөл ирүүлэгчийн хүсэлтийн дагуу албан бичгээр хариуг өгнө.</p>



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

*АНХААРАЛ
ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА*

